

Боловсролын хүн судлал ба суралцагчийн хүмүүншил, хөгжил

Доктор (*Sc.D*), Профессор О. Пүрэв
(Боловсролын хүрээлэнгийн ЭШ-ний
тэргүүлэх ажилтан)

Улаанбаатар

2017.04.13


Агуулга

- Боловсрол судлалын шинжлэх ухааны тогтолцоо
- Боловсролын хүн судлал (антропологи) юу судлах вэ?
- Хүний бие, хүрд (чакра), оюун, сэтгэлийн харилцан хамаарал
- Хүний бие ба хүрдний шүтэлцээ нь хөгжил, хүмүүншлийн нь далд үндэс
- Боловсролын хүн судлал ба хүний хөгжил, суралцахуйн суурь айнууд
- Нейро шинжлэх ухааны ололтоос
- Академич К.В.Судаков, П.К.Анохин нарын хүний сэтгэлийн боловсролын талаарх физиологи, сэтгэлзүйн үндэслэл
- Сэтгэлийн боловсрол олох суурь үндэс
- Эрдэмтэн хүний хэв маяг, онцлог шинж

**✓ Боловсрол судлалын ШУ-ны
тогтолцоо: Ерөнхий ангилал**

**✓ Боловсролын хүн судлал юу судлах
вэ?**

Боловсрол судлалын шинжлэх ухааны тогтолцоо: ерөнхий ангилал



БОЛОВСРОЛЫН ХҮН СУДЛАЛЫН СУДЛАХ ЗҮЙЛ:

Хүн боловсрол, соёлтой болоход, түүний бие, оюун, сэтгэл ямар бүтэц, мөн чанар, онцлог, хэв маягтай, тэр нь төрмөл болон олдмол ямар чадавхтай, түүнд нь нийцэн хөгжиж, төлөвших ямар мэдлэг, чадвар, харилцаа, хандлагыг бий болгох зүй тогтлыг илрүүлж, хүн бие, оюун, сэтгэлийн чадвар, гэгээрэлтэй болж, өөртөө хийгээд бусдад ээлтэй үнэт зүйл бүтээхүй, хамгаалахуйн асуудлыг Боловсролын хүн судлал буюу боловсролын антропологи судална.

БХС-Бие даасан салбар,салбар ухаан, мэдлэгийн салбар мөн үү ???

- Боловсролын хүн судлал манай улсад хүн судлал, нийгэм, соёлын болон улс төрийн, анагаахын антропологитой харьцуулахад бараг хөгжөөгүй байна.
- **Монгол онцлог:** Өдгөөгийн монголын хүүхэд, залуучууд нүүдлийн хийгээд суурьшмал соёл, иргэншлийн бүтээгдэхүүн . Нүүдлийн гэхээр уудам тал, цэнхэр тэнгэр, цэвэр экологи, дэлхийн зүрхэн газрын болон сансарын эрчим хүчний нөлөө, нөлөөлөл. Чих сонор, хараа хурц, хөдөлгөөн эвсэлтэй, ген бохирдоогүй, “би”-гээр өвчлөөгүй, талын эн, тэнгэрийн цараагаар сэтгэдэг, эцэг эх, төрөл садан, бусад хүмүүст ч элгэмсүү дотно харилцаатай. Ерөнхийгээс тусгай руу сэтгэдэг, аль ч нөхцөл байдалд дасан зохицох чадвартай, уужуу тайван зан, босоо хийморь. Эдгээр нь монгол хүний антропологийн онцлог шинжийн зарим жишээ.

Данзанравжаа: Монгол, Хятад, Тангад хүний тухай ??? О.П номын 23-р тал

- С.Паркинсон (Англи) 1956 онд хүний амьдралын үнэлэмжийн тухай бичихдээ: “ англичууд малайчуудын залхууг гайхах бөгөөд тэд өдрийн ихэнхийг дал модны сүүдэрт самрын сүү ууж, хэвтэж чөлөөтэй өнгөрүүлнэ. Харин англи хүн өглөөнөөс орой хүртэл нуруу тэнийхгүй ажиллах ба амьдралын эцсийн зорилгыг нь асуувал, насан өндөр болохдоо чимээ шуугиангүй нутагт жижиг цөөрөмтэй газар авч, байшингаа бариад амар тайван амьдарна гэж хариулна. Гэтэл англичуудын насаараа мөрөөддөг бүхэн малайчуудад төрөлхөөс нь заяасан байдаг ” гэж дүрсэлжээ.
- Монгол, Малай төстэй, экологийн хувьд, Монгол мал бол полу фабрикант –чанаад, идэхэд бэлэн
- Одоогоос 9 зууны тэртээ Хятадын бичгийн хүн Ли-гоу “ . . . Баруун хойт нутагт газар нь өндөр . . . Өндөр, хүйтэн тэр нутагт чийрэг биетэй, хүч тэнхээтэй хүмүүс амьдардаг, тэдний зан араншин догшин, хүсэл тэмүүлэл зориг шийдэмгийгээр онцлог” гэжээ.

Монгол хүний уугуул зан төрх:

- Чингисийн 85 онд монгол газраар явсан Европ жуулчин П.Карпини “Монголын дотор хэрүүл тэмцэл ба хүний амийг хорлох явдал огт үгүй, харилцан эелдэг найрамдуу, хэрэг зарга ховор, хулгай дээрэм үгүй учир аливаа юм ба авдар зэргийг цоожгүй гадна тавина. Хааяа мал алдах зүйл байвч олсон хүн нь хадгалж байх буюу эс бөгөөс уг эзэнд эгүүлэн тушаана.” хэмээснийг А.Амар гуай зориуд өөрийн бүтээлд иш татаж байдаг.
- Мөн “Монголчууд нэгэн нь нэгийг хүндэлж хоорондоо эвтэй найрамдалтай, хоол идшээ хувааж идэлцэнэ. Хоёр гурван хоног хоол идэхгүй явавч цатгалан мэт дуулж наадах зэргээр ер бачимдахгүй, халуун хүйтнийг сайнаар өнгөрүүлж чадна. Харилцан нэгэнд муу санах, хорлох явдалгүй, чадах чинээгээр бие биед туслалцана.” (Рашид Эд-Дин) тэмдэглэж байв. Эдгээр нь уугуул монгол хүний дүр.

Суурьшмал иргэншлийн сул, давуу тал ???

- Суурьшмал иргэншлийн сул тал гэвэл бараг бүхнийг эд, мөнгө, шуналаар харсан, хэт хувиа бодсон, миний хэрэг бүтвэл бусдынх хамаагүй гэсэн хандлага давамгайлна. Эдийн баялагийг чухалчилдгаас баян, ядуугийн ялгаа их. Манайд ч ийм болов.
- Худал хэлэх, хуурах, омгорхох, атаархах, ховлох, хорлох, бүлгэрхэх, хумслах, хонжих, хомголзох, матах, эсэргүүцэх гэх мэт үйл, үйлдэл зонхилох жишээтэй.
- Давуу нь аж үйлдвэржилт, шинжлэх ухаан, технологи өндөр хөгжсөн г.м.

Сэтгэлийн боловсрол чухал уу?

- Орчин үеийн боловсрол 200 гаруй жил хөгжиж, техник, технологи, материаллаг дэвшилд их анхаарч харин сэтгэлийн боловсролд сайн анхаарсангүй. Хүн хүнээ хайрлах, энэрэх дотоод сэтгэлийн боловсрол олгох хэрэгцээтэй болов. Жишээ нь, Далай багшийн дотоод сэтгэлийн боловсролын хөтөлбөр АНУ, Энэтхэгт хэрэгжиж, үр дүн нь 4-5 жилийн дараа гарна. АНУ-д Энэрэл нигүүлсэнгүйн хот, Асралын хот бий болж буй аж. Бүх хүн амар амгаланг хүсдэг. Амар амгаланг зүгээр хүсэх биш, бусдын төлөө зүтгэх, бусдад үйлчлэхийг нэн даруй хийвэл амар амгалан ирэх жишээтэй.

Сэтгэлийн ба ШУ-ч боловсролыг шүтэлцүүлэх.

- Бурхан багшийн оюун ухааны сургаалийг Наландрын их сургуулийн уламжлал гэдэг.
- Энэ нь хувь хүн, гэр бүл, дэлхий даяараа хэрхэн амгалан улсыг бий болгох тухай сургаал. Бид оюун санааны эрдэмд суралцах, боловсрол (залбирал, гүрэм, дормоо чадна) олох, орчин үеийн техник, технологид сайн суралцаж буй. Наландрын сургаалиар сэтгэлийн амар амгаланг олох тул, шинжлэх ухаанч боловсрол, энэ хоёрыг хослуулан хэрэглэвэл бид үнэхээр тогтвортой хөгжинө.

Хүний бие, хүрд (чакра), оюун сэтгэлийн харилцан хамаарал (матриц)

| Д/Д | БИЕ | ХҮРДҮҮД | ОЮУН, СЭТГЭЛИЙН ТӨРӨЛ |
|-----|---|--|---------------------------|
| 1 | Физик бие (махбоди -- физик бүтэцтэй, үйл хөдлөлтэй) | Үндэс хүрд муладхара-улаан (Амьдрах төв. “Амьдрал, үхлийн хаалга.” Материаллаг ахуйд нөлөөлнө. Бэлгийн энерги. Амьдралд шантрах зэрэг энэ төв гэмтсэнтэй холбоотой.) | Математик, логик оюун |
| 2 | Эпирэн-хийн бие (физик биеийн бүх мэдээллийг агуулдаг. Физик биетэй харилцан нөлөөлнө. 4-6 см зайтай) | Хувилгаан хүрд-хара хүрд-улбар шар Өөрийгөө бүтээлч илэрхийлэх, гэгээрэлд хүрэх, урам, ёсзүй, мэдлэг зохицуулна. | Үг ярианы оюун |
| 3 | Астрал бие (мэдрэл, сэтгэл хөдлөл, дүрс, хүслийг хариуцна. 10-15 см) | Наран сүлжээ-хара хүрд-шар (Зоригтой, эрэмгий, шийдэмгий, аливаад ялах хүсэл буюу “би” үзлийн төв болдог. Хувиа бодох, уурлах, үзэн ядах, атаархах, харамлах, дээрэлхэх, харгис хатуу хандах зэрэг сэтгэл хөдлөлийн сөрөг чанарын төв) | Хөдөлгөөн- орон зайн оюун |

4

Ментал бие (бодол санааны болон ойлголт, дүгнэлт хийх бие 25см.)

Зүрхний хүрд-ногоон (хийсвэр сэтгэхүйн төв. Хийсвэр ойлголт, үзэл баримтлалыг танин мэдэх төв. Бас хайрлах, хүнлэг хандах, бүтээлч үйлийг удирдах)

Логик оюун

5

Карма бие (Шалтгаан бие, үйлийн үрийн бие 30-40 см)

**Хоолойн хүрд-төгс жаргалангийн хүрд-цэнхэр
Гэгээрэлд хөтлөх,ирээдүйг угтан харах, нигүүлсэх**

Харилцааны оюун

6

**Будхи бие (зөн
билгийн буюу дээд
ухамсарын бие, дээд
ухамсартай
холбоотой
сэтгэлийн нэг хэсэг)**

**Гурав дахь мэлмий
хүрд- хар хөх
(Хүслүүд
орчлонгийн
энергитэй
холбогдох,
сэтгэлийн амар
амгаланд хүрэх)**

Хөгжмийн оюун


7

Атми бие (Амар
амгалангийн буюу
нирваан бие, дээд
“би” хүний бодгалийн
мөнхийн субстанци)

Титэм хүрд-хөх ягаан,
эсвэл цагаан
(дээд бие, дээд оюун
санаа, дээд тэнгэрээс
заяасан ухамсарын
төв. Зөн билиг, оюуны
эх сурвалж. Ийм
чадвартай хүн ерийн
хүний хэдэн сар,
хэдэн 7 хоног сурах
зүйлийг хэдхэн
минутаг сурдаг
онцлогтой)

Дотоод ертөнц-
сэтгэл хөдлөлийн
оюун

Хүний бие ба хүрдний шүтэлцээ нь хөгжил, хүмүүншлийн нь цогцлолын далд үндэс.



Зураг 2. Хүний биеийн хүрд

7. Титэм хүрд
6. Гурав дахь мэлмий хүрд
5. Хоолойн хүрд
4. Зүрхний хүрд
3. Наран сүлжээ хүрд
2. Хувилгаан хүрд-хара хүрд
1. Үндэс хүрд


Боловсролын хүн судлал ба хүний хөгжил, суралцахуйн суурь айнууд

Аффектив
(Сэтгэл мэдрэмж)

Когнитив
(сэтгэхүй, оюун)

Психомотор
(хөдөлгөөн, ур зүй)

Психомотор
(хөдөлгөөн, ур зүй)



Академич К.В.Судаков, П.К.

Анохин нарын үндэслэл:

- Гипоталамуст эргэлдэж буй сэтгэл хөдлөлийн сэрэл их тархины гадаргад өгсөн идэвхжих замаар, дотоод шүүрэл болон гүйцэтгэх эрхтнүүдэд уруудах замаар нөлөөлнө. Энэ нөлөөллийн механизмаар сэтгэл хөдлөлийн үед бие махбодид илрэх бүх зүйл тайлбарлагдана. Сэтгэл хөдлөлийн үед үйлдэл, төрх, хэл яриа өөрчлөгдөх, баярлах, гомдох г.м. Эдгээр нь сэтгэл хөдлөлийн ухамсарт захирагдах болно. Үүний зэрэгцээ сэтгэл хөдлөлийн нөлөөгөөр зүрх судасны үйл ажиллагаа, ходоод гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн түргэсэх жишээтэй. Эдгээр нь эрхтний үйл ажиллагаагаар илрэх сэтгэл хөдлөлийн ухамсарт захирагдахгүй тул сэтгэлийн тааламжгүй нөлөөлөл удаан хугацаагаар эсвэл, хэт хүчтэй илэрвэл өвчлөл эндэгдлээр тэргүүн байруудад ордог зүрх судас, мэдрэл сэтгэцийн эмгэг үүсэх үндсэн хүчин зүйлийн нэг болдог.(ЭМШУИС, 2006,хууд.418)
- Хүний тархины лимбийн тогтолцоо амегдала гэх эртний тархины үлдэгдэл бүтэц нь хүний сэтгэл хөдлөлийн биологи үндэс юм.

П.Анохины үндэслэл:

- П. К. Анохин (ОХУ): Хүний үйлийн афферент нийлэг (давамгайлах дур хүсэл), акцептор байгууламж, эфферент нийлэг нь түүний чиглэсэн зорилготой үйлийн физиологи механизм бөгөөд үүнийг мэдээллийг нэгтгэх (задлан шинжлэх, цэгцлэх), шийдвэр гаргах, улмаар өөрийн үйл, үйлдлийн хөтөлбөр боловсруулах, үйл, үйлдлийн үр дүн илэрч, түүнийг эргэх холбооны мэдээллийн тусламжтайгаар үнэлж, цэгнэх, цаашид хэрхэн үйлдэхээ төлөвлөх гэсэн системээр тодорхойлсон.


Нейро шинжлэх ухааны ололтоос

- Биологийн процесс ба хүний сурах үйл ажиллагааны харилцан үйлчлэлийг илүүтэйгээр ойлгохыг эрэлхийлж буй боловсролын салбарынхны сонирхлыг нейро шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтууд ихээхэн татаж байна. Жишээлбэл, хүний амьдралын янз бүрийн үе шатанд тархи хэрхэн хөгжиж, ажилладаг талаарх хамгийн сүүлийн үеийн шинэ соргог мэдлэг нь бидний хэдийд яаж сурдаг талаарх ойлголтыг гүнзгийрүүлэв. Сурах үйл ажиллагааны “ мэдрэмтгий үе”-ийн талаар гол гол бүтээлүүд анхаарлаа хандуулсан байдаг. Тухайлбал, хэл сурах хамгийн оргил үе нь хүүхэд насанд байдаг. Энэ нь бага насны хүүхдийн боловсролын ач холбогдлыг онцгойлон чухалчилж, хүүхэд бага насандаа олон хэл сурах боломжтойг тэмдэглэж байна

Хүний бие, оюун болон сэтгэл хөдлөл, танин мэдэхүйн хамаарлыг судлах???

- Зарим судалгааны бүтээлүүд нь тархины “ уян хатан байдал”-ыг онцлон авч үзэж, хүний тархи хүрээлэн буй орчны нөлөөний хариуд амьдралын туршид өөрчлөгдөх чадвартайг тодорхой харуулсан . Эндээс үзэхэд насан туршид суралцах үзэл санаа болон нас үл харгалзан бүх нийтийг сурах боломжоор хангах бодлого үндэслэлтэй болохыг бататгасан. Үүний зэрэгцээ, тархины зохистой үйл ажиллагаанд хоолны шим тэжээл, нойр, спорт, амралт, чөлөөт цаг зэрэг орчны олон хүчин зүйл нөлөөлдөг. Үүнтэй нэгэн адил **эрүүл бие ба оюун санааны хоорондын харилцан хамаарал, сэтгэл хөдлөл ба танин мэдэхүйн, задлан шинжлэх болон бүтээлч үйл ажиллагааны харилцан үйлчлэлийг таньж мэдэх иж бүрэн арга шаардлагатайг хүлээн зөвшөөрөх .** Нейро шинжлэх ухааны судалгааны шинэ чиглэлүүд нь төрөхөөс заяасан ба олдмол (nature-nurture) шинж чанарын харилцан уялдааны тухай ойлголтыг хөгжүүлж байна.
- Хүний тархийг хиймэл оюун ухаантай холбох, өөрөөр хэлбэл тархинд тусгай электрон аппарат суулгавал санах ойн багтаамж, үйлдлийн хурд энгийн үеийнхээс 1.9-7.8 % их болох аж. Роботоос хүний тархи хүчтэйг харуулах гэнэ.


Хүний (суралцагч) сэтгэлийн нисванисыг арилган хүмүүншүүлэхүй



Д.Данзанравжаа: “Мунхагийн харанхуй дотор тачаангуйгаар согтож, уурын мэсийг бариад, омгоор түлэгдэж, атаагаар энэлэн, зовлонгийн эвэршээлээр эмгэнэх амьтан бүр хөөрхий” гэж онож хэлжээ.

“Цагийн жамыг тодруулагч Цагаан шувуу” зохиолоос нь

Эрдэмтэн хүний хэв маяг



Эрдэмтэн хүний онцлог шинж

- Урам зоригтой, цөхрөлтгүй байх
- Өвөрмөц содон чанар: сэтгэлгээний бие даасан байдал, ургуулан бодохуй, совин, авьяас
- Сэтгэлгээ, ухаан: учир зүй, ой ухаан, туршлага, анхаарлаа төвлөрүүлэх чадвар, хийсвэрлэх чадвар
- Ёс зүй: шударга, үнэнч байх
- Байгальтай тогтоосон холбоо: ажиглах чадвар, техникийн дадал дүй
- Хүмүүстэй тогтоосон холбоо: өөрийгөө ба бусдыг ойлгох, ойр тойрныхоо хүмүүстэй нийцэх, бүлэг зохион байгуулах, бусдыг итгэн үнэмшүүлэх, тэдний үндэслэгээг сонсох чадвар

Анхааран сонссонд их баярлалаа.

Утас: 976-99170412, 976-11318424

Факс: 976-70153500

И-мэйл хаяг: Purevus@yahoo.com